



БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



МАЛ ТООЛЛОГО-2020

2021 он

ОРШИЛ

Монгол улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн хэмээн томъёолж, энэ ч утгаараа мал тооллогын ажлыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12 сарын 7-17 өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж явуулдаг ба 2020 онд нийтийг хамарсан “Ковид-19” цар тахалтай байсан тул тухай оны 12 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд явуулсан билээ.

Үүний дагуу дүүрэгт 2020 оны тооллогыг нийслэлийн Засаг даргын А/1282 тоот захирамж, дүүргийн Засаг даргын А/403 тоот захирамжаар энэ оны мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах ажлын хэсэг, тэдний ажиллах удирдамжийг батлуулан тооллогын хугацаанд амжилттай зохион байгуулж явууллаа.

Мал тооллогын дүнг нэгтгэсэн энэхүү судалгаа нь дүүргийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд сүүр мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Таван хошуу малыг бодод шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ – 1.5 бод
- 1 адуу – 1 бод
- 1 үхэр – 1 бод
- 6 хонь – 1 бод
- 8 ямаа – 1 бод

Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ - 5 хонь
- 1 адуу - 7 хонь
- 1 үхэр - 6 хонь
- 1 хонь - 1 хонь
- 1 ямаа - 0.9 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

- Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай
- Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай
- Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай
- Бог мал /хонь, ямаа/-тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

- Тэмээ - Өнгөрсөн жилийн төл 2, 3 настай
- Адуу - Өнгөрсөн жилийн төл 2 настай
- Үхэр - Өнгөрсөн жилийн төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүлэлтүүдийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт болон худалдаж авсан, шилжиж ирсэн

мал, зарлага тал нь худалдсан, шилжүүлсэн мал болон хэрэглээний зарлага, том малын зүй бусын хорогдол болно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

- 1 Буур – 20 ингэ
- 1 Азарга - 10 гүү
- 1 Бух - 25 үнээ
- 1 Хуц, ухна – 50-60 эм хонь, эм ямаа

Малын зүй бусын хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түмэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон малын тоог, оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямаа/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

- | | |
|-------------------------|--|
| • Хадлан өвс | 0.45 |
| • Таримал тэжээл | 0.35 |
| • Даршны ургамал | 0.25 |
| • Гар тэжээл, хужир шүү | 1.0 |
| • Үр тарианы хаягдал | 0.9 |
| • Лай | 0.4 |
| • Сүрэл | 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ. |

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна. Үүнд:

- Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс
- Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
- Шүүст тэжээл – Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал

Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно. Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО: 2020 оны мал тооллогоор хувийн малтай 832 өрх, үүнээс 588 өрх мал аж ахуй эрхэлж байна. Үүнийг өнгөрсөн онтой харьцуулахад:

Хүснэгт 1. Малтай, малчин өрх, хороогоор


		2017 он	2018 он	2019 он	2020 он
Нийт мал бүхий өрх	1-р хороо	150	166	167	174
	2-р хороо	81	80	89	98
	3-р хороо	166	155	152	169
	4-р хороо	170	186	170	210
	5-р хороо	145	144	164	181
Дүүргийн дүн		728	731	742	832
Үүнээс: Малчин өрх	1-р хороо	89	95	93	100
	2-р хороо	75	80	87	97
	3-р хороо	57	93	71	65
	4-р хороо	130	174	144	207
	5-р хороо	86	117	97	119
Дүүргийн дүн		437	559	492	588

2020 оны байдлаар хувийн малтай 832 өрх байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 90 (12.1%) өрхөөр өссөн байна. Мөн мал аж ахуй эрхэлж, малын ашиг шимийг амьжиргааны эх үүсвэрээ болгон амьдарч байгаа малчин өрх 588 байгаа нь өнгөрсөн оноос 96 (19.5%) өрхөөр өссөн байна.

Хүснэгт 2. Малтай болон малчин өрхийн ам бүл, малчдын тоо

		2017 он	2018 он	2019 он	2020 он
Нийт мал бүхий өрх		712	728	742	832
Түүний ам бүл		2 389	2 513	2 403	2725
Үүнээс: Малчин өрх		437	559	492	588
Түүний ам бүл		1 465	1 911	1 547	1869
Малчдын тоо		649	797	687	847
16-34 насны		152	194	151	199
35-аас тэтгэвэрт гарах насны		335	420	361	430
Тэтгэврийн насны		162	183	175	218
Нийт малчдаас эмэгтэй		277	323	281	378
Насны бүтэц					
16-34 насны		23.4	24.3	22.0	23.5
35-аас тэтгэвэрт гарах насны		51.6	52.7	52.5	50.8
Тэтгэврийн насны		25.0	23.0	25.5	25.7

Зураг 1. Малчдын тоо /насны бүлгээр/




Мал аж ахуйн салбарт 847 малчин ажиллаж байгаа бөгөөд насны бүлгээр авч үзвэл 23.5 хувь нь 16-34 насны, 50.8 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 25.7 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Нийт малчдын 387 нь буюу 45.7 хувь нь эмэгтэй малчид байна.

МАЛЫН ТОО, БҮТЭЦ: 2020 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр мал сүргийн тоо 194501 толгойд хүрч, өнгөрсөн оноос 5682 (2.8%) толгой малаар буурсан байна.

Хүснэгт 3. Малын тоо, төрлөөр

	2017 он	2018 он	2019 он	2020 он	2020/2019	
					зөрүү	хувь
Тэмээ	224	203	210	205	-5	-2.4
Адуу	13 391	14 652	16 066	15 294	-772	-4.8
Үхэр	14 563	15 866	16 823	18 067	1 244	7.4
Хонь	88 526	92 757	99 691	92 137	-7 554	-7.6
Ямаа	55 345	60 859	67 393	68 798	1 405	2.1
НИЙТ МАЛ	172 049	184 337	200 183	194 501	-5 682	-2.8

Зураг 2. Малын тоо, оноор



Энэ жилийн тооллогоор үхэр сүрэг 1244 толгой буюу 7.4 хувиар, ямаан сүрэг 1405 толгой буюу 2.1 хувиар тус тус өсч, тэмээн сүрэг 5 толгой буюу 2.4 хувиар, адуун сүрэг 772 толгой буюу 4.8 хувиар, хонин сүрэг 7554 толгой буюу 7.6 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Малын орлого, зарлага, төрлөөр

	Орлого					Зарлага			
	Худалдаж авсан,	Шилжиж ирсэн	Алдсан олдохгүй байсан мал олсон	Бэлэн тоологдсон төл	Зах зээлд борлуулсан	шилжүүлсэн	Алдсан олдохгүй байгаа мал	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бус хорогдол
Тэмээ	3	4	0	47	39	0	0	19	1
Адуу	1 166	1 028	33	3 371	3 925	1 493	22	639	291
Үхэр	1 484	1 123	10	5 308	3 312	1 606	9	1 414	340
Хонь	12 905	5 454	15	28 230	38 228	7 901	0	6 535	1 494
Ямаа	9 982	5 404	8	18 669	22 709	4 563	3	4 208	1 175
Дүн	25 540	13 013	66	55 625	68 213	15 563	34	12 815	3 301

Дээрх хүснэгтээс харахад энэ жил бэлэн тоологдсон төлөөр 55625 толгой, худалдаж авсан болон шилжиж ирсэн малаар 38619 толгой мал тус тус нэмэгдэж, харин 68213 толгой мал зах зээлд борлуулагдаж, 15563 толгой мал шилжүүлж, 34 толгой мал алдаж, 12815 толгой мал хүнсэнд хэрэглэж, 3301 толгой мал зүй бусаар хорогдсон байна.

Хүснэгт 5. Малын тооны бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд

	2017 он	2018 он	2019 он	2020 он	2020/2019	
					зөрүү	хувь
Бэлэн тоологдсон төл	44 960	55 968	59 094	55 625	-3 469	-5.9
Том малын зүй бусын хорогдол	3 273	2 589	1 897	3 301	1 404	74.0
Хээлтэгч малын тоо	80 759	80 667	92 364	90 903	-1 461	-1.6
Хээл хаясан хээлтэгч	2 007	755	6 232	3 696	-2 536	-40.7
Сувайрсан хээлтэгч	12 191	7 402	8 882	11 901	3 019	34.0

Дээрх хүснэгтээс харахад энэ жил бэлнээр тоологдсон төл өнгөрсөн оноос 3469 (5.9%) төлөөр бүүрч, том малын зүй бус хорогдол өнгөрсөн оноос 1404 (74.0%) толгойгоор нэмэгдэж, хээлтэгч малын тоо 1461 (1.6%) буурсан нь энэ жилийн малын тооны бууралтанд голлон нөлөөлсөн байна.


МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ: 2020 оны байдлаар нийт мал сүргийн 82.9 хувийг бог мал, 17.3 хувийг бод мал эзэлж байна. Нийт сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр доорх хүснэгтэнд гарган харуулвал:

Хүснэгт 6. Нийт малд эзлэх хувийн жин, төрлөөр

	2017 он	2018 он	2019 он	2020 он
НИЙТ МАЛ	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	0.1	0.1	0.1	0.1
Адуу	7.8	7.9	8.0	7.9
Үхэр	8.5	8.6	8.4	9.3
Хонь	51.5	50.3	49.8	47.4
Ямаа	32.2	33.0	33.7	35.4

Үүнээс харахад тэмээ, адуу, үхэр сүргийн эзлэх хувь сүүлийн 4 жил харьцангуй тогтвортой байна. Бог малын хувьд хонин сүргийн эзлэх хувь буурч ямаан сүргийн эзлэх хувь өссөн байна. Бог малын 57.3 хувийг хонин сүрэг, 42.7 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Зураг 3. Бог малын бүтэц



Энэ жил ямаан сүрэг 68798 толгойд хүрч өмнөх оноос 1405 толгой буюу 2.1 хувиар өссөн байна. Ямаан сүргийн тоо толгой болон бог малд эзлэх хувь сүүлийн 4 жил өсч байгаа нь бэлчээрийн даац болон сүргийн бүтцэд сөргөөр нөлөөлж байна.


МАЛЫН ТОО ХОРООГООР: Энэ жилийн тооллогоор 3 хорооны мал 1228 толгой буюу 2.6 хувиар буурч, бусад хороодын мал 6.2-22.1 хувиар өссөн байна. Доорх хүснэгтэнд хороодын 2019 онд тоологдсон малыг өмнөх онтой харьцуулан өсөлт бууралтыг тоо болон хувиар харуулж байна.

Хүснэгт 7. Малын тоо, хороогоор

		2017 он	2018 он	2019 он	2020 он	өсөлт, бууралт	
						тоо	хувь
хороогоор	1-р хороо	42 856	45 357	50 725	45 365	-5 360	-10.6
	2-р хороо	11 964	11 737	13 821	13 151	-670	-4.8
	3-р хороо	43 683	47 457	46 229	43 314	-2 915	-6.3
	4-р хороо	47 027	50 246	53 339	55 421	2 082	3.9
	5-р хороо	26 519	29 540	36 069	37 250	1 181	3.3
Дүүргийн дүн		172 049	184 337	200 183	194 501	-5 682	-2.8

ХУВИЙН /АМИНЫ/ МАЛЫН ТОО: Мал тооллогоор амины малын тоо 189639 толгойд хүрч нийт малын 97.5 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оноос 4481 толгой малаар буюу 2.3 хувиар буурсан байна.

Зураг 4. Амины мал



Хүснэгт 8. Хувийн малтай өрх, малын тоо

Он	Малтай өрх	Бүгд	Үүнээс:					1 өрхийн дундаж мал
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
2017	712	165 442	224	13 076	14 110	84 506	53 526	232
2018	728	178 604	203	14 293	15 421	89 090	59 597	245
2019	742	194 120	210	15 718	16 310	95 801	66 081	262
2020	832	189 639	205	15 038	17 760	89 078	67 558	228

2020 оны байдлаар амины малын 35.6 хувийг ямаа, 47.0 хувийг хонь, 7.9 хувийг адуу, 9.4 хувийг үхэр, 0.1 хувийг тэмээ эзэлж байна. Мөн энэ жил 1 өрх дунджаар 228 толгой малтай болсон нь өнгөрсөн оноос 34 толгой малаар буюу 13.0 хувиар буурсан байна.



Амины малтай 1 өрхөд дунджаар тэмээ 0.2 толгой, адуу 18.1 толгой, үхэр 21.3 толгой, хонь 107.1 толгой, ямаа 81.2 толгой ногдож байна.

ХУВИЙН /АМИНЫ/ МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ: Нийт малтай өрхийн 43.6 хувь буюу 354 өрх 100 хүртэлх толгой малтай, 20.1 хувь буюу 163 өрх 101-200 толгой малтай, 23.6 хувь буюу 192 өрх 201-500 толгой малтай, 9.0 хувь буюу 73 өрх 501-999 толгой малтай байна.

Хүснэгт 9. Малтай өрхийн малын бүлэглэлт

	Өрхийн тоо		Дүнд эзлэх хувь	
	2019 он	2020 он	2019 он	2020 он
0-100 малтай	310	354	41.8	43.6
101-200 малтай	149	163	20.1	20.1
201-500 малтай	166	192	22.4	23.6
501-999 малтай	78	73	10.5	9.0
1000-1499 малтай	29	22	3.9	2.7
1500-2000 малтай	4	3	0.5	0.4
2000 дээш малтай	6	5	0.8	0.6
Бүгд	742	812	100.0	100.0

1000 ба түүнээс дээш толгой малтай өрх 30 байгаа нь нийт өрхийн 3.7 хувийг эзэлж байна. Үүний 22 өрх 1000-1499 толгой мал, 3 өрх 1500-2000 толгой мал тоолуулсан байна. Энэ жил 2000 дээш толгой малтай 5 өрх тоологдсон байна.



Амины малтай нэг өрх дунджаар 3.4 ам бүлтэй байгаа бөгөөд 1 хүнд 69.7 толгой мал ногдож байна. Энэ нь өнгөрсөн оноос 11.1 толгой малаар буурсан байна.

ХЭЭЛТЭГЧ МАЛ: 2020 оны эцэст 90903 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оноос 1461 толгойгоор буюу 1.6 хувиар буурсан ба ингэ 14.4 хувиар, гүү 4.4 хувиар, эм хонь 6.8 хувиар буурч, үнээ 3.7 хувиар, эм ямаа 5.7 хувиар тус тус өссөн байна.


Хүснэгт 10. Хээлтэгч мал, төрлөөр

	2017 он	2018 он	2019 он	2020 он	2020/2019	
					тоо	хувь
Ингэ	74	59	90	77	-13	-14.4
Гүү	4 586	5 116	5 567	5 296	-271	-4.9
Үнээ	5 912	6 582	6 974	7 230	256	3.7
Эм хонь	42 832	44 192	47 880	44 617	-3 263	-6.8
Эм ямаа	27 355	28 516	31 853	33 683	1 830	5.7
Бүгд	80 759	84 465	92 364	90 903	-1 461	-1.6

Хээлтэгч мал нийт малын 46.7 хувийг эзэлж байгаа бөгөөд

- тэмээн сүргийн – 37.6 хувь
- адуун сүргийн – 34.6 хувь
- үхэр сүргийн – 40.0 хувь
- хонин сүргийн – 48.4 хувь
- ямаан сүргийн – 49.0 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 5. Хээлтэгч малын тоо



БЭЛЭН ТООЛОГДСОН ТӨЛ: Энэ оны мал тооллогоор бэлэн тоологдсон төлийн тоо 55625 толгой болж өнгөрсөн оноос 3469 толгойгоор буюу 5.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 11. Бэлэн тоологдсон төл, төрлөөр

	2017 он	2018 он	2019 он	2020 он	2020/2019	
					тоо	хувь
Ботго	25	33	36	47	11	30.6
Унага	2 214	3 147	3 589	3 371	-218	-6.1
Тугал	3 853	4 421	4 847	5 308	461	9.5
Хурга	25 017	30 078	31 511	28 230	-3 281	-10.4
Ишиг	13 851	18 289	19 111	18 669	-442	-2.3
Бүгд	44 960	55 968	59 094	55 625	-3 469	-5.9

Өнгөрсөн оны тооллогоор 92364 толгой хээлтэгч төллөхөөр тоологдсон бөгөөд

- хээлтэй малын орлогоор 17672 толгой мал нэмэгдэж
- доод наснаас төллөсөн хээлтэгч 777
- хээлтэй мал 14554 толгойг зарлагдаж
- хээл хаясан 3696 толгой мал
- сувайрсан хээлтэгч 11901 толгой мал тус тус хасагдаж 80662 толгой хээлтэгч төллөсөн нь нийт төллөх насны хээлтэгчийн 87.3 хувь байна.

Хүснэгт 12. Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр

	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан шилжиж ирсэн	Худалдсан шилжүүлсэн
Ботго	52	52	0	52	3	8
Унага	4354	4354	103	4251	300	1180
Тугал	5811	5811	193	5618	427	737
Хурга	42244	42273	1351	40922	2505	15197
Ишиг	28201	28258	1187	27071	2208	10610
Бүгд	80662	80748	2834	77914	5443	27732

2020 онд 80748 толгой төл хүлээн авсан бөгөөд 2834 толгой төл мал хорогдож төл бойжилт 96.5 хувьтай байна.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ: 2020 оны тооллогоор 3301 толгой том мал хорогдсон бөгөөд энэ нь оны эхний малын 1.6 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өнгөрсөн оноос 1404 толгойгоор буюу 74.0 хувиар өссөн байна. Нийт хорогдсон том малын 0.1 хувийг тэмээ, 9.9 хувийг адуу, 15.0 хувийг үхэр, 47.3 хувийг хонь, 27.7 хувийг ямаа эзэлж байна.

Хүснэгт 13. Том малын зүй бусын хорогдол, төрлөөр

	2017 он	2018 он	2019 он	2020 он	2020/2019 зөрүү дахин	
Тэмээ	-	-	-	1	1	100.0
Адуу	343	223	152	291	139	91.4
Үхэр	343	389	129	340	211	163.6
Хонь	1 349	1 026	830	1 494	664	80.0
Ямаа	1 238	951	786	1 175	389	49.5
Бүгд	3 273	2 589	1 897	3 301	1 404	74.0

Энэ онд хорогдсон нийт малын 127 (3.8%) толгой мал гэнэтийн аюулаар, 216 (6.5%) толгой мал өвчнөөр, 171 (5.2%) толгой мал зэрлэг амьтанд бариулж, 2787 (84.4%) толгой мал бусад шалтгаанаар хорогдсон байна.

Хүснэгт 14. Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

	2017 он	2018 он	2019 он	2020 он
Тэмээ	-	-	-	0.5
Адуу	2.4	1.7	1.0	1.8
Үхэр	2.4	2.7	0.8	2.0
Хонь	1.5	1.2	0.9	1.5
Ямаа	2.1	1.7	1.3	1.7
БҮГД	1.8	1.5	1.0	1.6

ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО: 2020 онд 1523 хээлтүүлэгч мал тоологдож өмнөх оноос 30 толгойгоор буюу 2.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 15. Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо

	Хээлтүүлэгчийн тоо	Үржлийн норм	2017 он	2018 он	2019 он	2020 он
Ингэ	2	20	25	20	45	39
Гүү	551	10	9	9	10	10
Үнээ	218	25	32	34	38	33
Эм хонь	419	50	110	111	108	106
Эм ямаа	337	60	98	93	102	100

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо адуун сүргээс бусад сүргийн хувьд алдагдаж байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 50-60 хээлтэгч ногдох ёстой атал тооллогоор хонь ямаан сүргийн хувьд 106 эм хонь, 100 эм ямаанд 1 хээлтүүлэгч ногдож байгаа нь үржлийн нормоос 1.5-2 дахин их байна.

БЭЛЧЭЭРИЙН ХҮРЭЛЦЭЭ: Манай дүүрэг 62020 га газар нутагтай 2020 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар 38634.5 га хөдөө аж ахуйн эдэлбэр газар байна. Үүнээс бэлчээрийн талбай 37864.1 га болсон байна. 2020 оны тооллогоор тоологдсон малын тоо хонин толгойд шилжүүлснээр 370540 болсон нь өнгөрсөн оноос 4255 толгой буюу 1.1 хувиар буурсан байна.

Зураг 6. Нутаг дэвсгэрийн хэмжээ



Хүснэгт 16. Бэлчээрийн даац

	2017 он	2018 он	2019 он	2020 он
Нийт малын тоо /хонин толгой/	320 572	346 305	374 795	370 540
Бэлчээрийн талбай	38 710.9	38 06.1	38 327.5	37 864.1
100 га-д ногдох малын тоо	828.1	894.7	977.9	978.6

Дүүргийн 100 га бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 978.6 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 0.7 толгой малаар буюу 0.07 хувиар өссөн байна.

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2021 оны 3 дугаар сарын 17